



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2024.11.07 № 1-6/698

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Ц.ТЭГШЖАРГАЛ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаал, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитыг гүйцэтгэн, аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 15... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ  
АУДИТОР



Ц.ТЭГШЖАРГАЛ ГАН-ӨЛЗИЙ

010030292



**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ,  
ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ**

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос гаргасан заавар,  
аргачлалын дагуу зардлыг хуваарилж, зарцуулсан байна.

Аудитын код: ГНАГ-2024/15-ШТА-НА-ДГА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2024 оны 11 сар</p>	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	Цахим хаяг: <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a>
	Утас: 70522734	У.Оюунтүлхүүр
	Аудитын менежер:	Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a>
	Утас: 70523020	Н.Мөнхнасан
	Аудитор:	Цахим хаяг: <a href="mailto:MunkhnasanN@audit.gov.mn">MunkhnasanN@audit.gov.mn</a>
		Н.Түвшинбаатар
		Цахим хаяг: <a href="mailto:TuvshinbaatarN@audit.gov.mn">TuvshinbaatarN@audit.gov.mn</a>

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт .....	2
Хүснэгтийн товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4-5
Ерөнхий мэдээлэл .....	6
<b>1.АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН, ЗАРЦУУЛСАН БАЙНА.</b>	
<b>1.1 Улсын төсвөөс олгох сонгууль зохион байгуулахтай холбогдох зардлыг журмын дагуу хуваарилсан байна.....</b>	<b>7-9</b>
1.1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 797.2 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.....	7-8
1.1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд 658.6 сая төгрөгийн зардлыг хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажилласан байна.....	8-9
1.1.3 Аймгийн улсын бүртгэлийн хэлтэс болон цагдаагийн газрын сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын төсөвлөлтийг дээд байгууллагаас төсөвлөн, хуваарилсан байна.....	
<b>1.2 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 2.2 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.....</b>	<b>10-13</b>
1.2.1 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	10-11
1.2.2 Аймгийн сонгуулийн хороо нь зардлын тайланг журмын дагуу гаргаж, харин зарим сумдын сонгуулийн хорооны тайланд гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.....	11-12
1.2.3 Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалт болон анхан шатны баримт бүрдэл, хийсэн ажлын тайлан мэдээг боловсруулахад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.....	-12
Дүгнэлт .....	13

### **Товчилсон үгийн тайлбар**

<b>ГНАГ</b>	<b>Гүйцэтгэл нийцлийн аудит</b>
ДГА	Дорноговь аймаг
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТАБ	Төрийн аудит байгууллага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШТА	Шууд тайлагналын аудит
МТБ	Мэдээлэл технологийн баг
ССХ	Сумын сонгуулийн хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай

**Хүснэгтийн товъёог:**

<b>Утга</b>	<b>Тайлбар</b>
Хүснэгт 1	СЕХ-оос АСХ-д хуваарилсан төсөв, эдийн засгийн ангиллаар
Хүснэгт 2	Сонгуулийн зардлын санхүүжилт
Хүснэгт 3	Улсын бүртгэл болон Цагдаагийн газрыг төсвийн хуваарилалт
Хүснэгт 4	Аймаг сумын төсвийн гүйцэтгэл
Хүснэгт 5	Зардал хооронд шилжүүлэн зарцуулсан зардлын гүйцэтгэл

**Дүрслэлийн товъёог:**

<b>Утга</b>	<b>Тайлбар</b>
График 1	Дорноговь аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан хөрөнгийн санхүүжилт, сонгуулийн хорооны ангиллаар (хувиар)

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 "Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.", Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 4.5-д заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.
<b>Аудитын зорилго, зорилт</b>	Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлангийн төлөвлөлт, зарцуулалтад дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн сонгуулийн хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.  Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:  1. Орон нутгийн сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөн, хуваарилж, зарцуулсан эсэх.  2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх.
<b>Аудитын хамрах хүрээ</b>	Аудитыг орон нутгийн ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд, Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст, Цагдаагийн ерөнхий газраас аймгийн Цагдаагийн газарт хуваарилсан сонгуулийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалуудыг хамруулан авч үзлээ.
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", А/71 дүгээр тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын заавар, аргачлал"-ыг баримтлан шалгагдагчийн сонгуулийн зардлын тайлан, холбогдох

	<p>баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> <p>Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:</p> <ul style="list-style-type: none"><li>▪ Төрийн аудитын тухай хууль</li><li>▪ Төсвийн тухай хууль</li><li>▪ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль</li><li>▪ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль</li><li>▪ СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”</li><li>▪ Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.</li></ul>
<p><b>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</b></p>	<p>Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, аудитор Н.Мөнхнасан, Н.Түвшинбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрөөс хугацаанд нь хэрэгжүүлж, аудитын тайланг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр холбогдох байгууллагад хүргүүллээ.</p>

## **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, тухайн оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 18/05 дугаар тогтоолоор аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг аймгийн ЗДТГ-ын дарга Н.Хонгорзулаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны Нягтлан бодогчоор аймгийн ИТХ-ын Нягтлан бодогч Б.Наранцацарал, бичиг хэргийн ажилтнаар аймгийн ИТХ-ын ажлын албаны хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн А.Уянга нарыг тус тус аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01, 02 дугаар тушаалаар томилон нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 3/777, 09 дүгээр сарын 05-ны өдрийн 3/834, 09 дүгээр сарын 12-ны өдрийн 3/852, 09 дүгээр сарын 23-ны өдрийн 3/893, 09 дүгээр сарын 27-ны өдрийн 3/909, 10 дугаар сарын 07-ны өдрийн 3/940 тоот албан бичгийн 2 дугаар хавсралтаар АСХ-нд нийт 797.2 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус хуваарилсан байна.

Дорноговь аймгийн сонгуулийн хороо болон 14 сумын сонгуулийн хороо, 65 хэсгийн хороо мөн сонгуулийг автоматжуулсан системээр зохион байгуулдагтай холбоотойгоор аймгийн Сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн багт 5, үндсэн болон нөөц даамлаар 86, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар 71, аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын хэлтсээс хамгаалалт, хяналт, хэв журам, хэрэг мөрдөн шалгах зэрэг чиглэлээр 145 албан хаагч томилогдон, нийт 892 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулах зардалд УБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар 66.2 сая төгрөг, ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 42.4 сая төгрөгийн төсөв тус тус хуваарилсан байна. Эдгээр байгууллагуудын улсын төсвөөс олгосон зардлын зарцуулалтын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгав.

Аймгийн Сонгуулийн хороонд нийт 797.2 сая төгрөгийг СЕХ-ноос хуваарилсныг аймгийн Төрийн сан дахь 100060022001 тоот дансаар дамжуулан гүйцэтгэлээр 795.6 сая төгрөг зарцуулж, 2.2 сая төгрөгийг хэмнэж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН, ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

### **1.1 Улсын төсвөөс олгох сонгууль зохион байгуулахтай холбогдох зардлыг журмын дагуу хуваарилсан байна.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг **Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж**, улсын төсвөөс санхүүжүүлнэ”, 10.2-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг **улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын** тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ”, 10.3-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг **цагдаагийн байгууллагын** тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 3/777, 09 дүгээр сарын 05,12,23,27-ны өдрийн 3/834, 3/852, 3/893, 3/909, 10 дугаар сарын 07-ны өдрийн 3/940 тоот албан бичгийн 2 дугаар хавсралтаар АСХ-нд нийт 797.2 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус хуваарилсан байна.

#### **1.1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 797.2 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1-т “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасан байна.

Дорноговь аймгийн харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд аймгийн сонгуулийн хороонд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 18/05 дугаар тогтоолоор батлагдсан 9 хүн, 14 сумын сонгуулийн хороонд 80 хүн, 65 сонгуулийн хэсгийн хороонд 482 хүн, нийт 585 хүн ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу үйлдэгдсэн, Дорноговь аймгийн хэмжээнд сонгуулийн хэсгийн хороодод хүргэсэн эхний нэрийн жагсаалтад нийт **45944** сонгогч бүртгэгдсэн байсан. Үүнээс хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, “түр хасав” төлөвийг хасах, лавлагаа мэдээллийг оруулан эцсийн байдлаар гаргасан нэрийн жагсаалтад **45951** сонгогч бүртгэгдсэн байна.

СЕХ нь Дорноговь аймгийн нийт сонгогчид болон сумдын санал авах байр тэдгээрт ажиллах гишүүдийн тоог үндэслэн сонгуулийн зардлыг төлөвлөн УИХ-аар батлуулж, аймгийн Сонгуулийн хороонд 797.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

**“Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэл”-д аудит хийж, дүгнэлт гаргах**

Хүснэгт 1. СЕХ-оос АСХ-д хуваарилсан төсөв, эдийн засгийн ангиллаар

№	Зардлын нэр	Төсөв		/сая төгрөгөөр/	
		АХС	СХХ	Нийт төсөв	Эзлэх хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1.1	-	1.1	0.1
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	11.5	-	11.5	1.4
3	МТБ, даамлын сургалт	17.2	-	17.2	2.2
4	Бичиг хэргийн зардал	1.0	10.5	11.5	1.4
5	Шуудан, холбооны зардал	1.5	12.6	14.1	1.8
6	Унааны зардал	2.4	55.9	58.3	7.3
7	Санал авах байр бэлтгэх зардал	-	19.6	19.6	2.5
8	Сурталчилгааны зардал	11.6	8.4	20.0	2.5
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1.3	-	1.3	0.2
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	38.3	-	38.3	4.8
11	Томилолтын зардал	12.7	-	12.7	1.6
12	Сүлжээний судалгаа хийх зардал	1.9	-	1.9	0.2
13	Саналын хуудас устгах зардал	1.3	-	1.3	0.2
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	-	6.7	6.7	0.8
15	Санал авах байрны түлшний зардал	-	7.2	7.2	0.9
16	Сурталчилгааны материал ашиглах унааны зардал	-	9.8	9.8	1.2
17	Шуурхай багийн зардал	2.8	-	2.8	0.3
18	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, НДШ, хоолны зардал	14.1	464.9	479.0	60.1
19	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ, хоолны зардал	19.6	57.2	76.8	9.6
20	Болзошгүй зардал	-	5.9	5.9	0.7
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>138.5</b>	<b>658.6</b>	<b>797.2</b>	<b>100.0</b>

СЕХ-оос АСХ-нд хуваарилсан зардлыг дийлэнх хэсгийг буюу 60.1 хувийг сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал эзэлж байгаа бол хамгийн бага хувийг хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал 1.1 сая төгрөг буюу 0.1 хувийг эзэлж байна.

**1.1.2 Аймагын сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд 658.6 сая төгрөгийн зардлыг хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажилласан байна.**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам" 2 дугаар зүйлийн 2.3-т "Аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь СЕХ-оос өгсөн тайлбар аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд зардлын төсвийг хуваарилна" гэж заасан байна.

СЕХ-оос аймагт 20 нэр төрлийн зардалд хуваарилсан 797.2 сая төгрөгийг зарцуулах зардлын ангилал болон сумын сонгуулийн хороонд хуваарилах зөвлөмж, аргачлалыг 6 удаа ирүүлсэн. Уг зөвлөмж, аргачлалын дагуу аймгийн Сонгуулийн хорооноос 14 сумдын сонгуулийн хороонд 658.6 сая төгрөгийн зардлыг хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажилласан байна.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын санхүүжилт

Байгууллагын нэр						/сая төгрөгөөр/	
	VIII/19	IX/05	IX/13	IX/23	IX/27	X/05	Нийт
Аймгийн Сонгуулийн хороо	29.8	4.9	63.9	3.2	2.8	33.7	138.5
Сумдын Сонгуулийн хороо	-	98.5	8.4	6.7	17.0	528.0	658.7
<b>нийт дүн</b>	<b>29.8</b>	<b>103.5</b>	<b>72.3</b>	<b>9.9</b>	<b>19.8</b>	<b>561.7</b>	<b>797.2</b>

АСХ нь сонгуулийн хороодын санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тооны судалгааг үндэслэн сум тус бүрд бичиг хэргийн зардалд 0.12-0.15 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0.15 сая төгрөг, санал авах байр бэлтгэхэд 0.28 сая төгрөг, унааны зардлыг АСХ-д 3500км\*700 төгрөг, ССХ-д 700км\*700 төгрөг, хэсгийн хороонд 1000км\*700 төгрөг-өөр тооцож хуваарилсан байна.




График 1. Дорноговь аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан хөрөнгийн санхүүжилт, сонгуулийн хорооны ангиллаар (хувиар)

### 1.1.3 Аймгийн улсын бүртгэлийн хэлтэс болон цагдаагийн газрын сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын төсөвлөлтийг дээд байгууллагаас төсөвлөн, хуваарилсан байна

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг **улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын** тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан.

Үүний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 8 нэр төрлийн 66.7 сая төгрөгийн зардлын санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

Хуваарилагдсан нийт зарцуулалтаас “Итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны урамшуулал, НДШ, хоол, унааны зардал” 0.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, “Томилолт, унааны зардал” 0.2 сая төгрөгөөр, “Сургалтын бусад зардал” 0.05 сая төгрөгөөр хасагдаж дахин хуваарилсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг **цагдаагийн байгууллагын** тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна. Үүний дагуу Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16/3171 тоот албан бичгээр Дорноговь аймгийн Цагдаагийн газарт 3 нэр төрлийн 42.4 сая төгрөгийн зардлын санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

Хамгаалалтын албан хаагчдын хоолны зардал 28.2 сая төгрөг, шатахууны зардал 3.0 сая төгрөг, Шуудан холбооны зардал 11.2 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

*Хүснэгт 3 Улсын бүртгэл болон Цагдаагийн газрыг төсвийн хуваарилалт*

№	Зардлын ангилал	Цагдаагийн газар	/сая төгрөгөөр/	
			Улсын бүртгэлийн хэлтэс	
1	Бичиг хэрэг	-	3.3	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	-	1.3	
3	Шуудан холбооны зардал	11.2	-	
4	Унааны зардал	3.0	8.2	
5	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	-	41.1	
6	Хоолны зардал	28.2	-	
7	Томилолтын зардал	-	12.1	
8	Шуурхай багийн зардал	-	0.2	
	<b>Нийт дүн</b>	<b>42.4</b>	<b>66.2</b>	

**1.2 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 2.2 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.**

**1.2.1 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

Дорноговь 2024 онд аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахтай холбоотойгоор аймгийн сонгуулийн хороонд хуваарилагдаж ирсэн 797.2 сая төгрөгөөс 20 төрлийн зардалд 795.0 сая төгрөг зарцуулж, 2.2 сая төгрөгийг СЕХ-д буцаан төвлөрүүлсэн байна.

Харин Сайншанд, Эрдэнэ сумын сонгуулийн хороо хуваарилсан зардлаас хэмнэгдсэн 190.5 мянган төгрөгийн зардлыг аймгийн сонгуулийн хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэлийг ангилал бүрээр авч үзэхэд зардлын хэтрэлт үүсээгүй байна.

*Хүснэгт:4 Аймаг сумын төсвийн гүйцэтгэл*

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				АСХ	ССХ
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1.1	1.1	0.0	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	11.5	12.9	-1.4	
3	МТБ, даамлын сургалт	17.2	17.2	0.0	
4	Бичиг хэрэг	11.5	11.5	0.0	
5	Шуудан холбооны зардал	14.1	14.0	0.1	
6	Шатахууны зардал	58.3	58.3	-	
7	Санал авах байр бэлтгэх зардал	19.6	19.6	-	
8	Сурталчилгаа	20.0	20.0	-	
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1.3	1.3	-	
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	38.3	37.1	1.2	
11	Томилолтын зардал	12.8	12.0	0.8	
12	Сүлжээний судалгаа хийх	1.9	1.0	1.0	
13	Саналын хуудас, устгах зардал	1.3	1.3	-	

**“Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэл”-д аудит хийж, дүгнэлт гаргах**

14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	6.7	6.7	-	
15	Санал авах байрны түлшний зардал	7.2	7.2	-	
16	Сурталчилгааны материал ашиглах унааны зардал	9.8	9.8	-	
17	Шуурхай багийн зардал	2.8	2.3	0.5	
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	479.0	479.0	-	
19	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	76.9	76.9	-	
20	Болзошгүй зардал	5.9	5.7	-	0.2
	<b>Нийт зардал</b>	<b>797.2</b>	<b>794.9</b>	<b>2.1</b>	<b>0.2</b>

Дээрх хүснэгтээс харахад аймгийн сонгуулийн хороо нь 8-н зардлын гүйцэтгэлд хэмнэлт үүсгэн төсвийг үр дүнтэй зардлын дагуу зарцуулсан байна.

**1.2.2 Аймгийн сонгуулийн хороо нь зардлын тайланг журмын дагуу гаргаж, харин зарим сумдын сонгуулийн хорооны тайланд гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.8 "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасан.

СЕХ-оос зардлыг эдийн засгийн ангиллын дагуу хэмнэлттэй байхаар зарцуулах чиглэлийг тухай бүр өгсөн ба АСХ тус зөвлөмж аргачлалыг баримтлан хэрэгжүүлэн ажиллажээ.

Хуваарилсан зардлыг журамд заасны дагуу АСХ-с төсвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх гэсэн чиглэл өгсөн хэдий ч зарим сумдын сонгуулийн хороо нь 6.2 сая төгрөгийн зардлыг шилжүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт:5 Зардал хооронд шилжүүлэн зарцуулсан зардлын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Сумын нэрс	Болзошгүй зардал		Байр тохижуулах
		Шатахуун	Байр тохижуулах	Шатахуун
1	Айраг	0.4	-	-
2	Алтанширээ	0.4	-	-
3	Даланжаргалан	0.5	0.1	-
4	Дэлгэрэх	0.2	0.3	-
5	Иххэт	0.1	0.2	-
6	Мандах	0.6	-	-
7	Өргөн	-	0.4	-
8	Сайхандулаан	0.4	-	-
9	Улаанбадрах	0.4	-	-
10	Хатанбулаг	0.7	-	0.2
11	Хөвсгөл	0.4	-	0.2
12	Эрдэнэ	0.6	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>4.8</b>	<b>1.1</b>	<b>0.4</b>

Тодруулбал байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдал хүндрэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын зориулалтаар болзошгүй зардалд 5.9 сая төгрөг хуваарилсан байна.

Дээрх сумдын сонгуулийн хороо хэсгүүд нь АСХ-ны зөвшөөрөлгүйгээр 5.8 сая төгрөгийг шатахууны зардалд, 1.1 сая төгрөгийг байр тохижуулах зардалд шилжүүлэн зарцуулсан байна. Хатанбулаг, Хөвсгөл сумд нь байр тохижуулах зардлаас 0.3 мянган төгрөгийг шатахууны зардалд шилжүүлэн зарцуулсан байна.

Хатанбулаг, Хөвсгөл сумд нь байр тохижуулах зардлаас 0.3 мянган төгрөгийг шатахууны зардалд шилжүүлэн зарцуулсан боловч сонгуулийн хороонд зардлын гүйцэтгэлийн тайланг хүргүүлэхдээ бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй хуваарилсан зардлын гүйцэтгэл дээр тайлагнан хүргүүлсэн байна.

Аудитаар сонгуулийн зардлын тайланг бодит гүйцэтгэлээр болгон залруулсан.

Орон нутгийн сонгуулийн зардлыг хуваарилахдаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал гэсэн эдийн засгийн нэг ангиллаар тусгаж өгдөг байна.

### **1.2.3 Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалт болон анхан шатны баримт бүрдэл, хийсэн ажлын тайлан мэдээг боловсруулахад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.**

Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны А/17 тогтоолоор баталсан *“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих”* журмын 3.10-т *“... аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зарцуулалтад хяналт тавина”*, мөн журмын 4.6-д *“...аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумын сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авна...”* гэж заажээ.

Үүний дагуу аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь 14 сумын сонгуулийн хорооны зардлын тайланг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон дансны хуулгаар тулган жагсаалт үйлдэн хүлээн авсан байна.

Сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг хүлээн авахад хяналт хийж Сайншанд, Замын-Үүд, сумын сонгуулийн хороо нь заавар журмын дагуу зардлыг зарцуулж тайлагнасан.

Сумдын сонгуулийн хорооны анхан шатны баримтыг тулган шалгаж аудит хийх явцад жолооч нарын замын хуудас, шаардах хуудас, явсан газрын маршрут, тойролтоор нийт явах замын км, шаардлагатай шатахууны тооцоолол гэх анхан шатны баримт бүрдэл бүрэн, эмх цэгцтэй ойлгомжтой шаардлага хангасан байна.

Энэ нь орон нутгийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу АСХ сумдын сонгуулийн хороог арга зүйгээр ханган хяналтыг хэрэгжүүлж, ажилласан байна.

### **АУДИТЫН ДҮГНЭЛТ**

1. СЕХ-оос Дорноговь аймгийн сонгуулийн хороонд 20 нэр төрлийн зардалд нийт 797.2 сая төгрөгийн санхүүжилтийг 6 үе шатаар хуваарилан олгосон ба тухай бүрд зардлын зүйл ангилал болон хөрөнгийг зарцуулах талаар холбогдох зөвлөмж, аргачлалыг ирүүлсэн байна.
2. УБЕГ-аас сонгууль зохион байгуулах 3-н нэр төрлийн зардалд 66.2 сая төгрөгийг аймгийн УБХ-т хуваарилсан байна.
3. ЦЕГ-аас аймгийн цагдаагийн газарт 8-н нэр төрлийн зардалд 42.3 сая төгрөгийг хуваарилан аймаг сумын сонгуулийн хороо болон хэсгийн хороонд үүрэг гүйцэтгэх албан хаагчдын нэрсийг жагсаалтаар баталсан байна.
4. Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороонд 658.6 сая төгрөгийг сонгуулийн ерөнхий хорооны заавар, аргачлалын дагуу хуваарилсан байна.
5. Орон нутгийн сонгуулийн зардлыг хуваарилахдаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал гэсэн эдийн засгийн нэг ангиллаар тусгадгаас болзошгүй зардалд хуваарилсан 6.2 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.
6. Аймаг сумын сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын тайлангийн анхан шатны баримт бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнан өмнөх аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн холбогдох хууль, журмыг мөрдөн ажилласан байна.

## АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/40

Сайншанд сум

#### Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт, 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд), аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Ц.Тэгшжаргал), Цагдаагийн газрын дарга хурандаа (Б.Батзориг), Сонгуулийн хорооны дарга (Н.Хонгорзул) нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.



ДАРГА ГАН-ӨЛЗИЙ

0100030061



Дарга, тэргүүлэх аудитор

Т.Ган-Өлзий

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :**

Аудитор:

Н.Мөнхнасан

Аудитор:

Н.Түвшинбаатар

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД  
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.**



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**“СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС  
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ”  
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: ГНАГ-2024/06-ШТА-НА

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a></p> <p>Сайншанд 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: <a href="mailto:gan-ulzii.t@audit.gov.mn">gan-ulzii.t@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70503020 Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: М.Дүүрэнжаргал Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:duurenjargalm@audit.gov.mn">duurenjargalm@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
Товчилсон үгийн тайлбар .....	3
Хүснэгтийн товъёог: .....	3
Графикийн товъёог: .....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:.....	6
БҮЛЭГ 1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ СОНГУУЛИЙН ЖИЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН БАЙНА.....	6
1.1.1. УИХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ЖУРМЫН ДАГУУ БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛСАН БАЙНА.....	6
1.1.2. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ӨГСӨН ЗААВАР, АРГАЧЛАЛЫН ДАГУУ ЗАРДЛЫГ ХУВААРИЛСАН БАЙНА.....	7
1.1.3. ЗАРИМ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ӨМНӨХ ТАЙЛАНД ХУГАЦААНД ТӨЛӨВЛӨСӨН, ГЭВЧ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЖИЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН БАЙНА.....	8
1.2. ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, 6.9 САЯ ТӨГРӨГИЙГ БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.....	9
1.2.1. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	9
1.2.2. ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ МАЯГТЫН ДАГУУ БОДИТОЙ ТАЙЛАГНАСАН БАЙНА.....	10
1.2.3. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.....	10
ДҮГНЭЛТ:.....	11

### **Товчилсон үгийн тайлбар**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нийцлийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ШТА	Шууд тайлагналын аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их Хурал

### **Хүснэгтийн товъёог:**

Хүснэгт 1: Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсөв (эдийн засгийн ангиллаар).....	6
Хүснэгт 2: Сонгуулийн зардлын санхүүжилтийн мөнгөн дүн, хугацаагаар.....	8
Хүснэгт 3: Зарим төрийн захиргааны байгууллагуудын сонгуулийн зардлын төсвийн төлөвлөлт.....	8
Хүснэгт 4: Сонгуулийн зардлын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын ангиллаар ...	9

### **Графикийн товъёог:**

График 1: Сонгуулийн зардлын санхүүжилтийн хуваарилалт, сонгуулийн хороогоор (сая.төгрөгөөр) .....	7
--	---

*Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл*

Аудит хийх  
үндэслэл,  
бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаал, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын  
зорилт

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гарган, аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын  
хамарсан  
хүрээ

Аудитад УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар болон бусад холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, нийтэд мэдээллээ.

Аудитын  
арга зүй,  
шалгуур  
үзүүлэлт

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.

Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлж, аудитор М.Дүүрэнжаргал төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитыг 2024 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хооронд гүйцэтгэж, дүнг нийтэд мэдээллээ.

## **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх (мажоритар) аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх (пропорциональ) аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Дорноговь аймгийн хэмжээнд сонгуулийн насны 44148 иргэн бүртгэлтэй бөгөөд үүнээс 30049 иргэн саналаа өгсөн байна.

УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд аймгийн Сонгуулийн хороонд 647.1 сая төгрөг, Цагдаагийн газарт 39.3 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 71.2 сая төгрөгийг баталж, хуваарилсан байна. Аймгийн Сонгуулийн хорооноос зарцуулагдаагүй 6.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### **БҮЛЭГ 1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ СОНГУУЛИЙН ЖИЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН БАЙНА.**

#### **1.1.1. УИХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ЖУРМЫН ДАГУУ БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛСАН БАЙНА.**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1<sup>1</sup> дэх хэсэг, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1<sup>2</sup> дэх заалтад сонгуулийн төсвийн хуваарилалтыг хуульчилсан байна.

Дорноговь аймгийн сонгуулийн хороо болон 65 хэсгийн ажиллах зардалд 5 удаагийн санхүүжилтээр нийт 647.1 сая төгрөгийг олгохоор баталж, хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

Хүснэгт 1: Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсөв (эдийн засгийн ангиллаар)

(сая төгрөгөөр)

№	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Нийт зардалд эзлэх хувь	
			1	2
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	0.30		0.05%
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	8.48		1.31%
3	Мэдээлэл технологийн баг, даамлын сургалт	15.33		2.37%
4	Бичиг хэрэг	10.90		1.68%
5	Шуудан холбооны зардал	12.85		1.99%
6	Унааны зардал	54.81		8.47%
7	Санал авах байр бэлтгэх зардал	20.15		3.11%
8	Сурталчилгаа	8.00		1.24%

<sup>1</sup> Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

<sup>2</sup> Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна.

9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	37.25	5.76%
10	Мэдээлэл технологийн багийн гишүүний холбоо, унааны зардал	1.30	0.20%
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	372.06	57.49%
12	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	52.98	8.19%
13	Хоолны зардал	34.50	5.33%
14	Томилолтын зардал	9.89	1.53%
15	Шуурхай багийн зардал	2.13	0.33%
16	Болзошгүй зардал	6.24	0.96%
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>647.17</b>	<b>100%</b>

Эх сурвалж. Аудиторын ажлын баримт


СЕХ-оос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсвийн 57.5 хувийг сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал, 13.5 хувийг мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал буюу нийт 71.0 хувийг урамшуулал, хоолны зардалд, унаа болон томилолтын зардалд 10.0 хувийг зарцуулахаар төлөвлөжээ. Зарцуулалтын тайлбар, хариу албан бичгээр харвал, зардлын төсвийг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тооцоолжээ.

### **1.1.2. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ӨГСӨН ЗААВАР, АРГАЧЛАЛЫН ДАГУУ ЗАРДЛЫГ ХУВААРИЛСАН БАЙНА.**

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 2.3-т "Аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь СЕХ-оос өгсөн тайлбар аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд зардлын төсвийг хуваарилна" гэж заасан.

СЕХ-оос олгосон санхүүжилтийг аймгийн сонгуулийн хороонд 228.1 сая төгрөг, сумдад дунджаар 29.9 сая төгрөгийг тус тус хуваарилжээ.

График 1: Сонгуулийн зардлын санхүүжилтийн хуваарилалт, сонгуулийн хороогоор (сая.төгрөгөөр)



Эх сурвалж. Аудиторын ажлын баримт

Нийт санхүүжилтийн 35.2 хувийг аймгийн сонгуулийн хороонд мэдээлэл технологийн баг, даамлын сургалт, сурталчилгаа, саналын хуудас, төхөөрөмжийн

авах, хүргэх ачаа, томилолтын зардал, сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулалд зарцуулахаар хуваарилжээ. Сумдын хувьд зарим зардлыг хуваарилах шаардлагагүй бөгөөд сумын сонгуулийн хороонд бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, хоол санал авах байр бэлтгэх, сонгуулийн хорооны гишүүдийн болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшууллын зардлыг багтаан хуваарилжээ.

СЕХ-ны Ажлын албаны 2024 оны 3/229, 3/290, 3/373, 3/472, 3/562 дугаар албан бичгүүдээр УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн зардлын төсвийн санхүүжилтийг зарцуулах хуваарь, дансны жагсаалт, тайлбар аргачлалыг тодорхой тусган, олгосон байна. Олгосон санхүүжилтийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2: Сонгуулийн зардлын санхүүжилтийн мөнгөн дүн, хугацаагаар

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	2024.04.18	2024.05.02	2024.05.20 2024.05.21	2024.06.07	2024.06.19	Нийт мөнгөн дүн
А	1	2	3	4	5	6=1+2+3+4+5
Сонгуулийн ерөнхий хороо	8.77	93.90	28.15	38.55	477.80	647.17

Эх сурвалж. Аудиторын ажлын баримт

Аймаг, сумдын сонгуулийн хорооны төсвийн хуваарь болон холбогдох тооцоолол тайлбарыг харахад нарийвчлан сайтар тооцоолсон байна.

### **1.1.3. ЗАРИМ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ӨМНӨХ ТАЙЛАНД ХУГАЦААНД ТӨЛӨВЛӨСӨН, ГЭВЧ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЖИЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН БАЙНА.**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3 дугаар хэсэгт улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулах зардлын ангиллыг хуульчилсан.

Дараах байгууллагуудын сонгуулийн зардлын төсвийг 2023 онд боловсруулсан бөгөөд албан томилолтын зардлыг тухайн үед мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалын дагуу төсөвлөж, батлуулсан. Гэвч 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс уг тушаалыг хүчингүй болгож, томилолтын зардлын хэмжээ шинэчлэгдсэн боловч албан хаагчдын томилолт, хоолны зардлыг батлагдсан төсвийн дагуу олгогдсон байна.

Хүснэгт 3: Зарим төрийн захиргааны байгууллагуудын сонгуулийн зардлын төсвийн төлөвлөлт (сая төгрөгөөр)

№	Зардлын ангилал	Цагдаагийн газар	Улсын бүртгэлийн хэлтэс
А		1	2
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	-	2.88
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	-	1.40
3	Шуудан холбооны зардал	10.94	1.91
4	Унааны зардал	2.00	8.62
5	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	-	44.79
6	Хоолны зардал	26.38	-
7	Томилолтын зардал	-	11.28
8	Шуурхай багийн зардал	-	0.35
<b>НИЙТ ДҮН</b>		<b>39.32</b>	<b>71.24</b>

Эх сурвалж. Аудиторын ажлын баримт

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/104 дүгээр тушаалаар сонгуулийн санал авах байруудыг улсын бүртгэлийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох (тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийх) зардалд 4.1 сая төгрөгийг нэмж хуваарилсан байна.

## **1.2. ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, 6.9 САЯ ТӨГРӨГИЙГ БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.**

### **1.2.1. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын А/17 захирамжаар батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1<sup>3</sup>-т заасны дагуу аймаг, сумдын сонгуулийн хороод мөнгөн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг хөтөлж, ажил гүйлгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн байна.

Хүснэгт 4: Сонгуулийн зардлын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын ангиллаар

№	Зардлын ангилал	(сая төгрөгөөр)	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	А	1	2
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	0.30	0.30
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	8.48	8.45
3	Мэдээлэл технологийн баг, даамлын сургалт	11.33	10.93
4	Бичиг хэрэг	10.90	10.90
5	Шуудан холбооны зардал	12.85	12.81
6	Унааны зардал	54.81	54.81
7	Санал авах байр бэлтгэх зардал	20.15	20.06
8	Сурталчилгаа	8.00	8.00
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	41.25	35.33
10	Мэдээлэл технологийн багийн гишүүний холбоо, унааны зардал	1.30	1.30
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	372.06	372.06
12	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	52.98	52.98
13	Хоолны зардал	34.50	34.50
14	Томилолтын зардал	9.89	9.89
15	Шуурхай багийн зардал	2.13	2.13
16	Болзошгүй зардал	6.24	5.74
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>647.17</b>	<b>640.18</b>

Эх сурвалж. Аудиторын ажлын баримт

Аймгийн сонгуулийн хороо нь 640.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 6.9 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ. Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардал нийт 5.9 сая төгрөгөөр, болзошгүй зардал 0.5 сая төгрөгөөр, мэдээлэл технологийн баг, даамлын сургалт 0.4 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна. Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардалд 4.0 сая төгрөгийг шилжүүлэх саналыг хүргүүлэн шийдвэрлэсэн боловч уг төсвийг зарцуулаагүй байна.

<sup>3</sup> Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө

Аймгийн болон сумын сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад хууль, журмын дагуу зарцуулсан байна.

### **1.2.2. ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ МАЯГТЫН ДАГУУ БОДИТОЙ ТАЙЛАГНАСАН БАЙНА.**

Сонгуулийн хороод нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу сонгуулийн зардлын тайланг тайлагнажээ. Мөн уг захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн зардлын тайлангийн иж бүрдлийг бүрэн хангасан байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг зардлын ангиллаар тулган шалгахад үүссэн зөрүү байхгүй болно.

### **1.2.3. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5-т “сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих”, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар журмын 3 дугаар зүйлийн 3.10-т “... аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зарцуулалтад хяналт тавина”, 4 дүгээр зүйлийн 4.6-д “Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сумын сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авна...” гэж заасан.

Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороодод хөрөнгийн зарцуулалтыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн анхан шатны баримтыг НББ-ийн тухай хуулийн дагуу бүрдүүлэн ажиллах зэрэг аргачлал, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллажээ.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар журмын 3 дугаар зүйлийн 3.3<sup>4</sup> дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаж байна.

Сонгуулийн зардлын ажил гүйлгээг бараа үйлчилгээний бусад зардал (210901)-ын дансны ангиллаар хийж, зарцуулсан нь батлагдсан зардлын ангиллын дагуу зарцуулж байгаа эсэхэд аймгийн сонгуулийн хорооноос хяналт тавих боломж хомс байна.

---

<sup>4</sup> 3.3.1. НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын дагуу магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг нягтлах бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн байх  
3.3.2. Төсвийн байгууллагад нягтлан бодогчоор 3-аас доошгүй жил ажилласан, бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх

### **ДУГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сонгуулийн хороодод хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
- Зарим төрийн захиргааны байгууллагуудын томилолтын зардлын төсвийг өмнөх тайланд хугацаанд төлөвлөсөн, гэвч ээлжит сонгуулийн жилд өөрчлөлт орсон байна.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулж, 6.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.
- Аймгийн сонгуулийн хороо нь хууль журмын бүрэн эрхийнхээ хүрээнд сонгуулийн зардалтай холбоотой аргачлал, тайлбар, зөвлөмжийн тухай бүр хүргэж, хяналтыг гүйцэтгэсэн байна.



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРОО**

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,  
Сайвшанд сум, Дорноговь аймаг, 44103  
Утас: (976) 7052 3036, факс: (976) 7052 3036  
Цахим шуудан: Dornogovisonguuli@gmail.com

2024.07.29 № 22

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ  
ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймаг, сумдын сонгуулийн хороодод Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн зардлын тайланд танай байгууллагаас ирүүлсэн аудитын тайлантай танилцлаа.

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд санал байхгүй болно.

СОНГУУЛИЙН ХОРООНЫ  
ДАРГА Н.ХОНГОРЗУЛ





ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/32

Сайншанд сум

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт, 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд), аймгийн Сонгуулийн хорооны дарга (Н.Хонгорзул) нарт тус тус хүргүүлсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

010010043

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

Аудитор



М.Дүүрэнжаргал

АУДИТЫН ХЯНАЛТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Аудитын менежер



У.Оюунтүлхүүр

Дарга, тэргүүлэх аудитор



Т.Ган-Өлзий